

БАТЛАВ
"ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ
ТӨХЖ-ИЙН УЛААНБААТАР САЛБАРЫН
ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР Б.БАЯРМАНДАХ

**110/35/10 КВ-ЫН БАЯНЧАНДМАНЬ ДЭД СТАНЦЫН БАРИЛГЫН ДЭЭВЭР, БОРООНЫ
УСНЫ ХАЯЛАГЫН ЗАСВАРЫН АЖЛЫН ДААЛГАВАР**

Барилгын ажлын техникийн тодорхойлолт нь барилга угсралтын ажлыг гүйцэтгэхдээ техникийн баримт бичгийн үндсэн бүрдэл хэсэг болох манай улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа "Барилгын норм, дүрэм", стандарт, техникийн нөхцлийг иж бүрэн баримтална.

Төндөрийн нарийвчилсан үнэлгээнд төсвийн тооцооны бодит байдал, ажлын үнэлгээний сонголт, ажлын хөдөлмөр зарцуулалтын дүн, түүний ажил гүйцэтгэх графиктай уялдсан байдал, зааснаас илүү, дутуу тооцсон эсэх зэргийг нарийвчлан хянаж дүгнэнэ.

Төсвийн тооцоонд цалин, материал, тээвэр, механизмын зардал, магадлашгүй ажил, нормчлолын сан, бусад шууд зардал, нэмэгдэл зардал, ашиг, захиалагчийн техник хяналтын зардал, нэмэгдсэн өртгийн албан татвар зэргийг улсын хэмжээнд одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа норм, дүрэм, заавар, тушаал, шийдвэрийг үндэслэн зохионо.

Гэрээнд тусгагдсан бүх ажлыг Монгол улсад мөрдөгдөж буй хууль, тогтоомж, БНБД, стандартын дагуу гүйцэтгэнэ.

Бүх бараа зайлшгүй шинэ, ашиглагдаагүй, олон улсын стандартад нийцсэн байна.

Барилгын ажлыг чанаргүй хийсэн тохиолдолд өөрийн хөрөнгөөр захиалагчийн заасан хугацаанд засварлаж өгнө.

Засвараас гарсан хог хаягдлыг тухайн дүүргийн зөвшөөрөгдсөн цэгт тээвэрлэж зайлуулахаар зардлыг тооцож санал ирүүлнэ.

Энэхүү бичиг баримтыг барилгын одоогийн план зураг болон өөрчлөлтийн план зурагнаас ажлын тоо хэмжээ нягтлан төсөвт тооцоолох

Ажлыг гүйцэтгэх талбайд ажиллаж буй ажилчдад хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны зааварчилгааг тогтмол өгч ажиллана.

Дээвэр: Материал нь Ризолин ФСa 2,5 мм зузаантай материал байна. Гадна орчны температур +60 градусын температурт тэсвэртэй байна. Бүх төрлийн материалаар хийгдсэн дээвэрт наах зориулалттай байх. Эг үе наах зориулалттай материал байна.

Материалын амсрын зөрүүлэг нь 10 см-с багагүй байна. Дээврийн ажлыг +15 градусаас дээш орчинд гүйцэтгэнэ. Дээврийн ус зайлуулах юүлүүр трасын байршил, налуулгыг дээврийн ажил гүйцэтгэх БНБД 31-07-05 дагуу хийнэ. Дээвэрт ус зайлуулах хормойвч хийх, БНБД 31-117-15 барилгын дээврийн агааржуулах сувгийн ажлыг хийнэ.

Ил ба далд ажлын актыг фото зургаар баталгаажуулж захиалагчаар хянуулсан байна.

Дээврийн хөндийрсөн хэсгийг хэвийн болгосоны дараагаар Мембран материал наах.


Дээврийн тоосгон хашлагийг төмрөөр бүрэх.

Ус зайлуулах хоолой нь үйлдвэрийн хийцлэлтэй байх ба ус хуримтлуулах талбай, дамжуулах хоолойн хөндлөн огтлол, чиглэл уналт зэргийг тооцож сонгох, цас болон мөсний даацыг тооцож давхар бэхэлгээ хийсэн байх. Босоо хоолойн буултыг барилгын хаяавчнаас 10 см илүү гаргаж хийх.

Ажлын тоо хэмжээ

Д/д	Ажлын нэр / Барилгын дээвэр/	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
1	Дээврийн хар цаас үзлэг хийж, шаардлагатай цэгүүдэд цементэн тэгшилгээ хийж, нөхөөс хийх	м ²	540
2	Дээвэрт нарийвчилсан цэвэрлэгээ хийж, өө сэв дарах	м ²	540
3	Дээврийн бетон ба зуурмаг тэгшилгээн дээр ус тусгаарлах үеийн хөрсжүүлэлт хийх	м ²	540
4	Ризолин дээвэр наах	м ²	540
5	Дээврийн тоосгон хашлагийг төмрөөр бүрэх	м	60
6	Усны хаялага хийж бэхлэх /иж бүрэн/	м	60
7	Дээврийн борооны ус зайлуулах хоолой	м	100
8	Агааржуулалтын сэнс суурилуулах	ш	1

Барилгын хэмжээ



ХЯНАСАН: АШУА-НЫ ДАРГА

С.Оулсидорж

З.ӨЛЗИЙБАЯР

БОЛОВСРУУЛСАН: АШИГЛАЛТЫН ИНЖЕНЕР

Ц.Уржинханд

Ц.ҮРЖИНХАНД